



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 12 сарын 23 өдөр

Дугаар А/668

Хэрлэн сум

Аймгийн "Оны шилдэг"-ийн
шагналд хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, аймгийн Засаг даргын 2015 оны А/562 дугаар захирамжаар баталсан "Оны шилдэг ажилтан, байгууллага" шалгаруулах журмыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн 2022 оны шилдэг байгууллага, ажилтны шагналд 4,900,000 (дөрвөн сая есөн зуун мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.


2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн шагнал урамшуулал, буцалтгүй тусламжийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 23-ны дугаар захирамжийн хавсралт

Зардлын тооцоо

№	Бараа материалын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт
1	Өргөмжлөл	ш	4	80,000	320,000
2	Цом	Ш	8	60,000	480,000
3	Дагалдах мөнгөн дүн	Ш	5 /байгууллага/	500,000	2,500,000
4	Дагалдах мөнгөн дүн	ш	8 /Хүн/	200,000	1,600,000
Нийт үнэ					4,900,000